

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА- 2024\45\НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/183
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 91,6 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020417

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	171,414,743.74	110,104,017.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	95,560,295.44	17,784,904.96
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	95,560,295.44	17,784,904.96
31210	Төгрөг	95,560,295.44	17,784,904.96
31211	Төрийн сангийн харилцах	95,560,295.44	17,784,904.96
33	АВЛАГА	10,701.75	6,094,134.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1.39	4.69
33101	Цалингийн авлага	1.39	4.69
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		6,083,429.00
33500	Бусад авлага	10,700.36	10,700.36
33510	Байгууллагаас авах авлага	0.36	0.36
33520	Хувь хүмүүсээс авах авлага	10,700.00	10,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	75,843,746.55	86,224,978.42
35100	Түүхий эд материал	70,154,906.55	81,776,698.42
35110	Тусгай зориулалттай материал	37,620,962.46	46,206,696.32
35130	Эм боох материал	32,533,944.09	35,570,002.10
35400	Хангамжийн материал	5,688,840.00	4,448,280.00
35410	Бичиг хэргийн материал	508,300.00	134,300.00
35420	Аж ахуйн материал	994,900.00	950,550.00
35460	Хүнсний материал	4,185,640.00	3,363,430.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	465,440,145.24	501,336,494.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	465,440,145.24	501,336,494.44
39200	Биет хөрөнгө	458,024,187.21	494,012,494.38
39201	Барилга, байгууламж, орон сууц	323,862,330.00	323,862,330.00
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(21,305,099.13)	(27,209,191.17)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,580,000.00	53,580,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(14,710,000.14)	(24,376,000.26)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	126,134,422.50	199,245,144.00
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(33,335,432.66)	(54,159,783.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,358,813.00	35,283,813.00
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(6,560,846.36)	(12,213,817.97)
39300	Биет бус хөрөнгө	7,415,958.03	7,324,000.06
39301	Програм хангамж	1,265,000.00	1,265,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(975,041.97)	(1,066,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,126,000.00	7,126,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	636,854,888.98	611,440,511.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	636,854,888.98	611,440,511.87
51	Засгийн газрын хувь оролцоо	636,854,888.98	611,440,511.87
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,404,778.19	191,404,778.19
511001	Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан	191,404,778.19	191,404,778.19
51200	Хуримтлагдсан үр дүн	225,569,316.74	200,154,939.63
51210	Өмнөх үеийн үр дүн	113,774,274.85	225,569,316.74
51220	Тайлант үеийн үр дүн	111,795,041.89	(25,414,377.11)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	219,880,794.05	219,880,794.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	636,854,888.98	611,440,511.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	657,532,884.12	661,628,042.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	173,498,154.12	90,505,601.65
1200	Нийтлэг татварын бус орлого	87,769,035.99	90,393,201.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,000,000.00
120004	Туслах үйл ажиллагааны орлого		1,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	59,239,296.50	64,828,824.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	28,529,739.49	24,564,377.15
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	85,729,118.13	112,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	82,843,920.00	
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,885,198.13	112,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	484,034,730.00	571,122,440.96
1310	Улсын төсвөөс		(79.52)
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		(79.52)
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,760,100.00	23,646,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,760,100.00	23,646,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	468,274,630.00	547,476,220.48
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	468,274,630.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		547,476,220.48
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	545,737,842.23	677,095,895.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,737,842.23	677,095,895.52
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	545,737,842.23	677,095,895.52
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	301,278,731.12	353,024,035.32
210101	Үндсэн цалин	296,720,351.12	338,909,400.80
210102	Нэмэгдэл	127,380.00	5,163,410.08
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4,431,000.00	3,649,000.00
210104	Урамшуулал		5,302,224.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,779,678.55	44,266,715.34
210201	Тэтгэврийн даатгал	27,381,818.55	29,906,293.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,003,912.00	3,664,448.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,403,129.00	3,258,431.61
210204	Ажилгүйдлийн даатгал	544,620.00	663,757.92
210205	Эрүүл мэндийн даатгал	5,446,199.00	6,773,783.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,445,298.13	22,558,620.48
210301	Гэрэл, цахилгаан	1,798,050.13	2,558,931.48
210302	Түлш, халаалт	15,317,248.00	19,709,689.00
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	290,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	47,188,049.90	65,932,993.09
210401	Бичиг хэрэг	3,972,350.00	2,116,150.00
210402	Тээвэр, шатахуун	24,869,899.90	32,095,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	810,200.00	1,013,800.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	33,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,502,600.00	20,176,000.00
210408	Бараа материал актласны зардал		10,441,843.09
2105	Нормативт зардал	92,930,927.46	95,989,752.19
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,807,837.46	75,110,542.19
210502	Хоол, хүнс	16,123,090.00	20,879,210.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,500.00	4,220,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		70,400.00
210604	Урсгал засвар	35,500.00	4,150,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	4,500,300.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	4,500,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		981,628.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		190,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		50,000.00
210807	Газрын төлбөр		11,628.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,579,657.07	85,621,451.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,411,339.00	35,565,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	37,168,318.07	50,055,951.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	111,795,041.89	(15,467,852.91)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		9,946,524.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		9,946,524.20
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		9,946,524.20
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	111,795,041.89	(25,414,377.11)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	623,428,348.13	566,151,411.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	85,729,118.13	1,112,400.00
1200	Нийтлэг татварын бус орлого		1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		1,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого		1,000,000.00
1230	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	85,729,118.13	112,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	82,843,920.00	
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,885,198.13	112,400.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	537,699,230.00	565,039,011.96
1310	Улсын төсвөөс		(79.52)
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг		(79.52)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,664,500.00	
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	53,664,500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	15,760,100.00	23,646,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,760,100.00	23,646,300.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	468,274,630.00	541,392,791.48
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	468,274,630.00	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		541,392,791.48
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	538,446,033.69	643,926,802.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538,446,033.69	643,926,802.44
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,446,033.69	643,926,802.44
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	301,688,332.59	353,560,917.00
210101	Үндсэн цалин	194,683,176.74	212,024,816.16
210102	Нэмэгдэл	72,462,307.71	95,431,139.19
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	4,133,448.14	3,414,265.65
210104	Урамшуулал	30,409,400.00	42,690,696.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,014,253.47	43,729,836.96
210201	Тэтгэврийн даатгал	28,996,593.35	29,473,763.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,317,330.95	3,453,740.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,853,924.92	2,596,084.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,545.84	744,868.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,405,858.41	7,461,381.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,445,298.13	22,558,620.48
210301	Гэрэл, цахилгаан	1,798,050.13	2,558,931.48
210302	Түлш, халаалт	15,317,248.00	19,709,689.00
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	290,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,737,749.90	36,644,300.00
210401	Бичиг хэрэг	2,894,450.00	1,062,900.00
210402	Тээвэр, шатахуун	24,869,899.90	32,095,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,205,500.00	1,436,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,767,900.00	2,049,300.00
2105	Нормативт зардал	80,823,799.60	78,762,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	63,823,799.60	58,388,100.00
210502	Хоол, хүнс	17,000,000.00	20,057,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		316,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,700,000.00	59,050,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	36,350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	8,000,000.00	3,500,300.00
210604	Урсгал засвар	6,700,000.00	19,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,500,000.00	4,500,300.00
210702	Дотоод албан томилолт	2,500,000.00	4,500,300.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		981,628.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		430,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		190,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		50,000.00
210807	Газрын төлбөр		11,628.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		100,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,536,600.00	44,138,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,536,600.00	44,138,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	84,982,314.44	(77,775,390.48)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	84,982,314.44	(77,775,390.48)
14	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,577,981.00	95,560,295.44
15	Мөнгө, түүнтэй адилтах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	95,560,295.44	17,784,904.96

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,880,794.05	113,774,274.85	525,059,847.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,404,778.19	219,880,794.05	113,774,274.85	525,059,847.09
9	Тайлант үеийн үр дүн			111,795,041.89	111,795,041.89
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,880,794.05	225,569,316.74	636,854,888.98
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,404,778.19	219,880,794.05	225,569,316.74	636,854,888.98
19	Тайлант үеийн үр дүн			(25,414,377.11)	(25,414,377.11)
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,404,778.19	219,880,794.05	200,154,939.63	611,440,511.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		95,560,295.44		
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дан		95,560,295.44		
12	Татварын бус орлого	616,342,900.00	565,151,491.48	51,191,408.52	91.69
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	588,402,700.00	541,392,791.48	47,009,908.52	92.01
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас	27,940,200.00	23,758,700.00	4,181,500.00	85.03
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН	711,903,300.00	643,926,881.96	67,976,418.04	90.45

21	УРСГАЛ ЗАРДАЛ	711,903,300.00	643,926,802.44	67,976,497.56	90.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	711,903,300.00	643,926,802.44	67,976,497.56	90.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшувал	409,860,700.00	353,560,917.00	56,299,783.00	86.26
210101	Үндсэн цалин	265,471,700.00	212,024,816.16	53,446,883.84	79.87
210102	Нэмэгдэл	93,024,200.00	95,431,139.19	(2,406,939.19)	102.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,204,400.00	3,414,265.65	(1,209,865.65)	154.88
210104	Урамшуулал	49,160,400.00	42,690,696.00	6,469,704.00	86.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгал	49,639,900.00	43,729,836.96	5,910,063.04	88.09
210201	Тэтгэврийн даатгал	33,755,000.00	29,473,763.96	4,281,236.04	87.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,972,000.00	3,453,740.00	518,260.00	86.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,177,400.00	2,596,084.00	581,316.00	81.70
210204	Ажилгүйдлийн даатгал	793,200.00	744,868.00	48,332.00	93.91
210205	Эрүүл мэндийн даатгал	7,942,300.00	7,461,381.00	480,919.00	93.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтвор	26,740,200.00	22,558,620.48	4,181,579.52	84.36
210301	Гэрэл, цахилгаан	3,418,000.00	2,558,931.48	859,068.52	74.87
210302	Түлш, халаалт	22,992,200.00	19,709,689.00	3,282,511.00	85.72
210303	Цэвэр, бохир ус	330,000.00	290,000.00	40,000.00	87.88
2104	Хангамж, бараа материалын зардал	36,657,400.00	36,644,300.00	13,100.00	99.96
210401	Бичиг хэрэг	1,062,900.00	1,062,900.00		100.00
210402	Тээвэр, шатахуун	32,095,200.00	32,095,200.00		100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,450,000.00	1,436,900.00	13,100.00	99.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгч	2,049,300.00	2,049,300.00		100.00
2105	Нормативт зардал	79,449,400.00	78,762,000.00	687,400.00	99.13
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,388,100.00	58,388,100.00		100.00
210502	Хоол, хүнс	20,061,300.00	20,057,000.00	4,300.00	99.98
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	316,900.00	683,100.00	31.69
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,900,300.00	59,050,300.00	850,000.00	98.58
210601	Багаж, техник хэрэгсэл	37,200,000.00	36,350,000.00	850,000.00	97.72
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,500,300.00	3,500,300.00		100.00
210604	Урсгал засвар	19,200,000.00	19,200,000.00		100.00
2107	Томилолт, зочны зардал	4,500,300.00	4,500,300.00		100.00
210702	Дотоод албан томилолт	4,500,300.00	4,500,300.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,016,200.00	981,628.00	34,572.00	96.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл то	430,000.00	430,000.00		100.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00		100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,000.00	190,000.00		100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	50,000.00		100.00
210807	Газрын төлбөр	46,200.00	11,628.00	34,572.00	25.17
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчи	100,000.00	100,000.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,138,900.00	44,138,900.00		100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	44,138,900.00	44,138,900.00		100.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		79.52	(79.52)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		79.52	(79.52)	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮС		1,000,000.00	(1,000,000.00)	
35	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,000,000.00	(1,000,000.00)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос са		1,000,000.00	(1,000,000.00)	
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		17,784,904.96		
12100	Үүнээс: Банкн дахь харилцах дан		17,784,904.96		10

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв 2023 оныг "Эх хүүхдийг дэмжих" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 4 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 91,6 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 14 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 90,6 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 91,2 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,414.3 мянган төгрөгөөр буюу 3,9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	95,560.2	17,784.9	-77,775.3
Авлага	10.7	6,094.1	-6,083.4
Урьдчилгаа			
Бараа материал	75,843.7	86,224.9	10,381.2
Үндсэн хөрөнгө	465,440.1	501,336.5	35,896.4
Нийт хөрөнгө	636,854.8	611,440.5	-25,414.3
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	636,854.8	611,440.5	-25,414.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	636,854.8	611,440.5	-25,414.3

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 77,775.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны үлдэгдэл 6,094.1 мянган төгрөг болж өмнөх оноос 6,083.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилт дутуу орж ирсэнээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 35,869.4 мянган төгрөгөөр өссөн нь Аймгийн эрүүл мэндийн газраас эм, эм боох материал 20,674.9 мянган төгрөг, тусгай зориулалтын материал 3,889.4 мянган төгрөгийн материал тус тус хүлээн авсантай холбоотой.

Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 501,336.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 35,896.4 мянган төгрөгөөр өссөн нь Аймгийн эрүүл мэндийн газраас 35,678.8 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 29,150.0 мянган төгрөгийн хөрөнгө тус тус хүлээн авсантай холбоотой байна.

Сумын ИТХ-н 2023 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 03 тоот тогтоолоор тоног төхөөрөмж 17,068.1 мянган төгрөг, тавилга 795.0 мянган төгрөг нийт 17,863.1 мянган төгрөгийн хөрөнгө актласан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 683,963.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 27,940.2 мянган төгрөг нийт зарлагыг 711,903.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 711,903.2 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 711,903.2 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 683,963.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 27,940.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 711,903.2 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 620,168.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 23,758.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, нийт 643,926.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 643,926.8 мянган төгрөг буюу 90,45 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 67,976.4 мянган төгрөгөөр, үүнээс цалин нэмэгдэл, урамшуулал 56,299.7 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 4,181.5 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 13.1 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 687.4 мянган төгрөгөөр, бүх төрлийн даатгалын зардлыг 5,910.0 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	71802 Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
80302	1 иргэнд ноогдох нормативт зардал	461,453.9	403,381.0	58,072.8	87,4%
81603	Үндсэн мэргэжилийн тусламж үйлчилгээ	126,948.8	121,276.8	5,671.9	95,5%
83601	Нэмэлт	1,000.0			
83603	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	95,560.3	95,510.3	50.0	99,9%
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	27,940.2	23,758.6	4,181.5	85%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71802-80302	2023-12-31	1 иргэнд ноогдох нормативт зардал	87,4%	461,453.9	403,381.0
2	71802-81603	2023-12-31	Үндсэн мэргэжилийн тусламж үйлчилгээ	95,5%	126,948.8	121,276.8
3	71802-83601	2023-12-31	Нэмэлт		1,000.0	
4	71802-80111	2023-12-31	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	85%	27,940.2	23,758.6
5	71802-83603	2023-12-31	Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	99,9%	95,560.3	95,510.3

Нэг иргэнд ноогдох нормативт зардал арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь орон тоо дутуу цалин, нэмэгдэл хэмнэсэнээс шалтгаалсан байна. Төрийн өмчийн барилгын тогтмол зардал дутуу хэмнэгдсэн нь халаалтын зардал хэмнэсэнтэй холбоотой.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг сумын худалдан авах ажиллагааны газрын зөвшөөрөлтэй Угтаалцайдам сумын Заяа ХХК-аас нийлүүлдэг байна. Худалдан авах ажиллагааны 2023 оны төлвөлгөөг батлуулж зохих хууль, журмын дагуу гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар , аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор

Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн 05 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 455,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 9,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,280.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага 3 заалт бүхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажилласны үр дүнд ажиллагсад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх 4 төрлийн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 56,299.7 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 5,031.6 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон нормативт зардлыг 700.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус Эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 154 мэдээллийг байршуулж 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны

цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д "өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Угтаалцайдам сумын Эрүүл мэндийн төвийн эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт 1, албан шаардлага 1, зөвлөмж 1 нийт 3 зөрчлийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	64.5	1	64.5	100
Албан шаардлага	1	794.5	1	794.5	100
Зөвлөмж	1	31.880.6	1	31.880.6	100
Нийт дүн	3	32,739.6	3	32,739.6	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардлын болон эргэлтийн эмийн сангийн цахим төлбөрийн баримтууд татварын цахим системд нэг регистрээр бүртгэгдэж байна. Үүнээс үүдэн эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын гүйлгээний хяналтын тогтолцоо алдагдах эрсдэл үүсэж байгаа асуудлыг дараагийн аудитаар авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 46,409.8 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 203.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 46,206.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Анхан шатны бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2023 оны 1-р сарын тогоочийн тайлангаар 205 хүн хэвтэн эмчлүүлсэнийг батлагдсан орц нормаар тооцоход 12 кг мах илүү зарцуулсан буюу 203.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 тоот тушаалын 3-р хавсралтаар батлагдсан жишиг нормыг дагаж мөрдөөгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хангамжийн материал, түүхий эд материал, тусгай зориулалттай материал зэрэг балансийн дансны ангилал зөрүүлж бүртгэсэнийг залруулах 46,206.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах",гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дансны ангилалыг хянаж ажиллахыг зөвлөв

Дээрх төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	/мянган төгрөгөөр/ Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн										
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Балансын дансны ангилал зөрүүлж бүртэгсэн	1	46,206.6					1	46,206.6				
2023 оны 1-р сарын тогоочийн тайлангаар 205 хүн хэвэн эмчлүүлсэнийг батлагдсан орц нормаар тооцоход 12 кг мах илүү зарцуулсан	1	203,2	1	203,2								
Дүн	2	46,409.8	1	203.2			1	46,206.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Шилэн дансанд байршуулах 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1										1	
Дүн	1										1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn